

БАТЛАВ:
ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА С.БАТЖАРГАЛ

БАТЛАВ:
ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН
ДАРГА Д.МӨНХБАТ

БАТЛАВ:
“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Х.БАДАМСҮРЭН

ОРХОН АЙМАГ, “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН
2021 ОНЫ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 оны 11 дугаар сарын 19

Орхон аймаг

№	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Санхүүжилт /сая.төг/	Хүрэх үр дүн
1	2	3	4	5	6	7
Байгаль орчин, экологийн чиглэлээр:						
1.	“Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Жилдээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын БОНХХ, “Эрдэнэт сувиллын цогцолбор”	ХОХБТХ, БОАЖГ	Батлагдсан төсвийн дагуу	Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр цагаан тоосны дэгдэлтийг бууруулна.
2.	Эрдэнэт хотын агаарын чанарын хяналт, судалгааг сайжруулах зорилгоор байгаль орчны шинжилгээний лабораторийг РМ 2,5 тоос хэмжигч багажаар хангах	Жилдээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын БОНХХ	БОАЖГ, УЦУОШТ	-	Агаарын бохирдолтын түвшинг нарийвчлан тогтоох боломж бүрдэнэ.
3.	Дулааны цахилгаан станцаас гарч байгаа үнсэн сангийн үнсийг зөөж булах газрыг хамтран шийдвэрлэх	2021-2023	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ Эрдэнэтийн ДЦС ТӨХК	Аймгийн ЗДТГ ГХБХБГ	Зохион байгуулалтын арга хэмжээ	Эвдэрч эзэнгүй орхигдсон газарт үнсийг зөөж булсны дараа нөхөн сэргээлт хийгдсэн байна.
Хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:						
4.	БОЭТөвийн Гемодиализийн тасаг, архив, ажилчдын хувцас солих өрөөний засварын 2019 онд хийсэн ажлын санхүүжилтийг шийдвэрлэх	Жилдээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ББХТХ	ЭМГ	37.7	Тасгийн ажилчдын ажиллах орчин нөхцөл сайжирч, сэтгэл ханамж дээшилсэн.
Дэд бүтэц, нийгмийн асуудлын чиглэлээр:						
5.	“Орон сууц” төсөл хэрэгжүүлэх	2021-2023	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Аймгийн ЗДТГ	ХОХБТХ	1500,0	Айл өрхийг орон сууцаар хангах, аймгийн орон сууцны санг нэмэгдүүлнэ.
6.	“Metil town”-ы 40 айлын орон сууцны хорооллын гадна дулаан, хэрэглээний халуун, хүйтэн усны шугамын ажлыг гүйцэтгэх	Жилдээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ББХТХ	ХЗА	262.3	Айл өрхийн ая тухтай амьдрах нөхцөл бүрдэнэ.

7.	Орхон аймгийн 11 дүгээр хорооллын А хэсгийн амины орон сууцны хорооллыг дулаанаар хангах инженерийн шугам сүлжээний хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	Жилдээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ББХТХ	Аймгийн ЗДТГ	-	11“А” хорооллын дулааны асуудал бүрэн шийдвэрлэгдэнэ.
8.	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйлдвэрлэлийн болон нийгмийн чиглэлийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд хуулийн хүрээнд туслалцаа үзүүлэх, хэвийн, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх	Жилдээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын НХХ	Аймгийн ЗДТГ	Зохион байгуулалтын арга хэмжээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйлдвэрлэлийн болон нийгмийн чиглэлийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд 100 хувь амжилттай хэрэгжих боломж бүрдэнэ.
9.	“Эрдэнэт сувиллын цогцолбор”-ын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авахад хамтран ажиллах	Жилдээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын НХХ	НБХ, ЭМГ	Зохион байгуулалтын арга хэмжээ	Хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломж бүрдэнэ.
10.	2020-2021 оны хичээлийн жилд боловсруулж батлуулсан “Сургалтын хөтөлбөр”-ийг /Үндсэн хичээлүүдийг орос хэл дээр заадаг/ үргэлжлүүлэх	Жилдээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын НХХ	НБХ, БСУГ	Зохион байгуулалтын арга хэмжээ	Сурах нөхцөл бүрдэнэ.
11.	Хиагтын 4 дүгээр сургууль болон боловсролын байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээг үргэлжлүүлэн байгуулж тэдний сургалтын хөтөлбөрийг 19 дүгээр сургуульд хэрэгжүүлэх, төгсөх ангийн Монгол, Орос сурагчдыг хос гэрчилгээтэй төгсгөх ажлыг зохион байгуулах	Жилдээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын НХХ	НБХ, ХОХБТХ, БСУГ	Зохион байгуулалтын арга хэмжээ	Сурагчид хос гэрчилгээтэй төгсөх, Монгол сурагчид ОХУ-д үнэ төлбөргүй дээд боловсрол эзэмших боломж бүрдэнэ.
12.	Ерөнхий боловсролын 19 дүгээр дунд сургуулийн гадна талбайд байрладаг хоккейн талбайн ашиглалтын асуудлыг эцэслэн шийдвэрлэх	Жилдээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 19-р сургууль	Боловсрол, соёл, урлагийн газар	Зохион байгуулалтын арга хэмжээ	Ерөнхий боловсролын 19 дүгээр дунд сургуулийн гадна талбайд байрладаг хоккейн талбайн өмчлөлийн асуудал бүрэн шийдвэрлэгдэнэ.
Ажлын байр нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр:						
13.	Эрдэнэт ШУТП, “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	Жилдээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ЭЦДС	“Эрдэнэт ШУТП” “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль	“Эрдэнэт ШУТП”-ийн санхүүжилтээр	Орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллана.
14.	Орон нутгийн их, дээд сургуулиудын дэргэд оюутны гарааны бизнесийг хөгжүүлэх “Стартап гараж” төсөл хэрэгжүүлэх	Жилдээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ЭЦДС	“Эрдэнэт ШУТП”	“Эрдэнэт ШУТП”-ийн санхүүжилтээр	Оюутны гарааны бизнесийг хөгжүүлэх 2 контейнер тохижуулж 4 бизнесийг хөгжүүлсэн байна.

Бусад чиглэлээр:						
15.	Байгалийн гэнэтийн үзэгдэл, цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх болон онцгой шаардлагатай үед үүргийн дагуу хамтран ажиллах	Жилдээ	Аймгийн ЗДТГ, ОБГ, АОК, ХЗА	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	Зохион байгуулалтын арга хэмжээ	Тусгай зориулалтын автомашин, механизмаар үйлчлэх болон бусад төрлийн дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
16.	“Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумдын багууд Эрдэнэт үйлдвэртэй шефийн харилцаа тогтоож хамтран ажиллах	Жилдээ	ТЗУХ, ХЗА, Сумдын ЗДТГ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын НХХ	Зохион байгуулалтын арга хэмжээ	Харилцан хамтран ажилласнаар гарах үр дүн нэмэгдэнэ.
17.	“Ковид-19” цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор Орхон аймагт дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Ерөнхий захирлын Хамтын ажиллагаа, Нийгмийн асуудал хариуцсан орлогч, НХХ	Аймгийн ЗДТГ	100.0	Орхон аймгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ сайжирна.
18.	Эрдэнэт хот байгуулагдсаны түүхт 45 жилийн ойд зориулан дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Ерөнхий захирлын Хамтын ажиллагаа, Нийгмийн асуудал хариуцсан орлогч, НХХ	Аймгийн ЗДТГ	100.0	Хамтран зохион байгуулна.
19.	Ус хэмжүүрийн 4 путикийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх	Жилдээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ЭХХ, УХЦ	Аймгийн ЗДТГ	Зохион байгуулалтын арга хэмжээ	Усны зарцуулалт болон усны алдагдлыг бүрэн хянах боломж бүрдэнэ.
20.	Хамтын ажиллагааны гэрээний дагуу хийгдсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг иргэд, олон нийтэд тогтмол сурталчлах	Жилдээ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын НХХ, МХ	Аймгийн ЗДТГ-ын мэдээллийн төв	Зохион байгуулалтын арга хэмжээ	Хамтын ажиллагааны талаар иргэдийн ойлголт нэмэгдэнэ.
Нийт дүн					2.000,0	

Товчилсон үгийн тайлбар:

ОРХОН АЙМАГ

ТЗУХ - Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
 ХОХБТХ - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
 БОАЖГ - Байгаль орчин, аялал жуулчлалын газар
 УЦУОШТ - Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
 ХЗА - Хотын захирагчийн алба
 НБХ - Нийгмийн бодлогын хэлтэс
 ЭМГ - Эрүүл мэндийн газар
 БСУГ - Боловсрол, соёл, урлагийн газар
 ГХБХБГ - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
 ОБГ - Онцгой байдлын газар
 АОК - Аймгийн онцгой комисс

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ

ЗХНБГ - Захиргаа, хүний нөөцийн бодлогын газар
 ХААХ - Худалдан авах ажиллагааны хэлтэс
 ББХТХ - Барилга, байгууламжийн хяналт, төлөвлөлтийн хэлтэс
 НХХ - Нийгмийн харилцааны хэлтэс
 МХ - Маркетингийн хэлтэс
 БОНХХ - Байгаль орчин, ногоон хөгжлийн хэлтэс
 ЭЦДС - “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль
 ЭСЦ - Эрдэнэт сувиллын цогцолбор

ЗӨВШИЛЦСӨН:

ОРХОН АЙМАГ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧ ~~А. ТҮВШИНЖАРГАЛ~~

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХОТ БАЙГУУЛАЛТ ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧ ~~М. ТҮМЭНЖАРГАЛ~~

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА ~~Д. СОЁЛЧХҮҮ~~

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САХХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ~~Н. БЯМБАЦЭЦЭГ~~

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА ~~М. МӨНХБАЯР~~

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ~~С. ДАВААДОРЖ~~

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨҮГ

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН НЭГДҮГЭЭР ~~ОРЛОГЧ~~ ~~БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР~~ ~~Т. БАТМӨНХ~~

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН САХХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ ХАРИУЦСАН ОРЛОГЧ ~~Д. ҮҮРИЙНТУЯА~~

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, НИЙГМИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧ ~~Ц. БАТ-ЭНХ~~

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧ ~~П. ЭНХБАТ~~

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ~~Х. БОЛДБААТАР~~

НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА ~~ДӨНӨБАТ~~

**ОРХОН АЙМАГ, “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2021 оны 11 сарын 19 өдөр

№

Орхон аймаг

Энэхүү гэрээг нэг талаас Орхон аймгийг төлөөлж Орхон аймгийн Засаг дарга С.Батжаргал /цаашид гэрээний тал гэх/, нөгөө талаас “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг төлөөлж Ерөнхий захирал Х.Бадамсүрэн /цаашид гэрээний тал гэх/ нар Засгийн газрын болон Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, орон нутгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын хөгжлийн чиг хандлагын хүрээнд 2021-2023 онд хамтран ажиллах зорилгоор харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, Гамшгийн тухай хуулийн 34 дүгээр зүйл, Иргэний хуулийн 476-480 дугаар зүйл, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Засгийн газрын 2012 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 222 дугаар тогтоол энэхүү гэрээний нийтлэг үндэслэл болно.

1.2. Энэхүү гэрээ нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын болон орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, энэхүү төсөл, хөтөлбөр нь орон нутгийн иргэдийн эрх ашгийг дэмжсэн, орон нутгийн хөгжилд хувь нэмэр болохуйц, үр дүнг нь тооцох боломжтой байх зарчимд тулгуурлан хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.3. Гэрээний талууд тэгш, шударга ёсны зарчмыг үндэслэн үр дүнтэй, ил тод, харилцан ач холбогдол бүхий хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.

1.4. Газар, түүний хэвлий, байгалийн нөөц баялаг ашиглан үйлдвэрлэл эрхэлж, олсон орлогоос орон нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй аливаа төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлж хамтран ажиллах, орон нутгийн хөгжилд нийгмийн хариуцлагын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас оруулж буй үнэтэй хувь нэмэр гэдгийг талууд хүлээн зөвшөөрч байна.

Хоёр. Аймгийн Засаг даргын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд аймгийн Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.



2.1.1. Гэрээний 3.1.1-д заасан хөрөнгийг Төсвийн тухай хуулийн хүрээнд захиран зарцуулах,

2.1.2. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг хангах,

2.1.3. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг боловсруулж, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан батлах, энэ тухай иргэдэд мэдээлэх,

2.1.4. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт тавих, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдлыг бууруулах талаар хамтран ажиллах, гэм хорыг арилгуулах талаар шаардлага тавих,

2.1.5. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж хариу өгөх,

2.1.6. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйлдвэрлэлийн болон нийгмийн чиглэлийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд хуулийн хүрээнд туслалцаа үзүүлэх, хэвийн, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

2.1.7. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас аймгийн иргэдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, бүтээн байгуулалт зэрэг арга хэмжээ, энэ чиглэлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг болох зорилгоор олгож буй мөнгөн хөрөнгийн тайланг жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор нийтэд мэдээлнэ.

Гурав. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын эрх, үүрэг

3.1. Энэхүү гэрээний хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. Тухайн жилийн улс орны эдийн засгийн нөхцөл байдал, зэсийн үнийн түвшин, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас баталсан бизнес төлөвлөгөө, үйлдвэрийн газрын орлого, ашгийн төлөвлөгөөний биелэлт зэргийг харгалзан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас орон нутагт жилд 2 тэрбумаас доошгүй төгрөгийн мөнгөн хөрөнгийг аймгийн иргэдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, бүтээн байгуулалт, энэ чиглэлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг болох зорилгоор жил бүр хөрөнгө оруулна.

3.1.2. Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийг сар бүр төлж, жилийн эцэст тооцоо нийлэн хянан баталгаажуулах,

3.1.3.Хуулийн хүрээнд үйлдвэрийн болон нийгмийн чиглэлийн үйл ажиллагаа хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх,

3.1.4.Агаарын бохирдлыг бууруулах, хөдөө аж ахуйн өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хамтран төсөл хэрэгжүүлэх

3.1.5.Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын багуудыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын бүтцийн нэгжүүдтэй хамтарч ажиллах талаар Ерөнхий захирлын тушаал гаргаж хэрэгжүүлэх,

3.1.6.Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэднийг технологийн сургуулийн сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллах,

3.1.7.Хүн амын боловсрол, эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах.

Дөрөв.Гэрээний хэрэгжилт

4.1.Энэхүү гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх, гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын албан ёсны вэб хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна.

4.2.Талууд жил бүрийн хамтын ажиллагааны төлөвлөгөөг батлах бөгөөд төлөвлөгөө нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3.Төлөвлөгөөний биелэлтийг талуудын ажлын хэсэг гаргаж дүгнэн, үр дүнг дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор тайлагнана.

Тав. Маргаан шийдвэрлэх

5.1.Талуудын аливаа санал зөрөлдөөн, маргаан гарсан тохиолдолд асуудлыг аль болох эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.Тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Гэрээ хүчин төгөлдөр болох

6.1.Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

6.2.Талуудын гарын үсэг зурсан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр байна.

6.3.Хуульд заасан үндэслэлээр гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.

6.4.Талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт гэрээний нэгэн адил хүчинтэй

байх бөгөөд түүний салшгүй нэг хэсэг болно. Талууд бичгээр үйлдэж, гарын үсэг зураагүй бол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахгүй бөгөөд бичгээр үйлдэж, гарын үсэг зураагүй нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр бус байна.

Долоо. Гэрээ байгуулсан талуудын хаяг:

Орхон аймгийн Засаг Даргын Тамгын газар, хаяг:
61033. Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртбулаг баг
Баян-Өндөр сум
Амарын талбай, Нутгийн удирдлагын ордон
Найрамдал талбай
Утас:70355590, 70352621
Факс:757-73002

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, хаяг:
61027, Орхон аймаг,
Хүрэнбулаг баг,
Утас:757-73501,

 <p>ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА <i>[Signature]</i> Д.МӨНХБАТ</p>	<p>ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:</p> <p>ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА <i>[Signature]</i> С.БАТЖАРГАЛ</p>	 <p>“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭРТӨҮГ-ЫН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ” ТӨҮГ <i>[Signature]</i> Х.БАДАМСҮРЭН</p>
<p>ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ <i>[Signature]</i> М.ТҮМЭНЖАРГАЛ</p>	<p>ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН НӨГДҮГЭЭР ОРЛОГЧ БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР <i>[Signature]</i> Т.БАТМӨНХ</p>	
<p>ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ <i>[Signature]</i> А.ТҮВШИНЖАРГАЛ</p>	<p>ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ ХАРИУЦСАН ОРЛОГЧ <i>[Signature]</i> Д.ҮҮРИЙНТУЯА</p>	
<p>АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА <i>[Signature]</i> Д.СОЁЛЧХҮҮ</p>	<p>ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, НИЙГМИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧ <i>[Signature]</i> Ц.БАТ-ЭНХ</p>	
<p>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА <i>[Signature]</i> С.ДАВААДОРЖ</p>	<p>ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧ <i>[Signature]</i> П.ЭНХБАТ</p>	
<p>ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА <i>[Signature]</i> М.МӨНХБАЯР</p>	<p>ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА <i>[Signature]</i> Х.БОЛДБААТАР</p>	
<p>САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА <i>[Signature]</i> Н.БЯМБАЦЭЦЭГ</p>	<p>НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА <i>[Signature]</i> Д.ӨНӨБАТ</p>	